



**“МӨНХИЙН БАЯН ГАЛ” ХХК**  
**Munkhiin Bayan Gal Co.,Ltd.**

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН  
НУТАГТ БАЙРЛАХ “МӨНХИЙН БАЯН ГАЛ”  
ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын  
мэргэжилтэн

**Хэрэгжилтийг гаргасан :**  
Мөнхийн баян гал ХХК-ны  
Ерөнхий захирал

**Боловсруулсан:**

БО,ХАБЭА мэргэжилтэн



/ П.Шинэцэцэг /

/ Ван Мао /

/ Д.Даваарэгзэн /

## Агуулга

1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
1. Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг захиргааны харъяалал .....	3
1.2. Үйлдвэрийн байгууламжийн ерөнхий бүтэц зохион байгуулал т .....	4
1.3 Үйлдвэрийн тоон мэдээлэл.....	5
1.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал мэдээлэл. ....	6
.....	6
1.5 БОННУ-ний тайлан. ....	9
.....	9
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	9
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ .....	12
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	13
4.2 Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт .....	17
4.3 Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	19
4.4 Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	21
4.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	25
5. ТҮҮХ,СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	27
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	31
8. БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ.....	33
9. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	35
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ.....	36

## УДИРТГАЛ

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх:

Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчинд нөлөөлөл багатай ажиллах нөхцөл бололцоог хангаж ажиллахад туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулах:

Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах:

Тус компани нь ашиглалтын үйл ажиллагаа явагдаж буй орчинд байгаль орчны зохистой менежментийг бий болгохын тулд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

Төслийг дэвшилтэд технологи, байгаль орчинд ээлтэй, чанарын өндөр баталгаатай үйлдвэрлэх технологийг мөрдөж, DCS хяналтын систем нэвтрүүлэн, сүүлийн үеийн тоос шүүх дэвшилтэд технологи ашиглаж, үйлдвэрийн энерги зарцуулалтыг хамгийн доод хэмжээнд хүргэнэ.

Төсөл нь хуурай аргаар цемент үйлдвэрлэх технологи ашиглаж Улаанбаатар дахь цахилгаан станцын хаягдал үнс, төмрийн үйлдвэрийн хаягдал зэрэг материалын хольц болгон цемент үйлдвэрлэдэг. Цементийн өртгийг бууруулан тээврийн зардлыг хэмнэж Монгол улсын зах зээлд хямд үнэтэй, өндөр чанартай цемент болон чулуунцар үйлдвэрлэнэ. Монгол улсын цементийн үнийг тогтворжуулж, цемент үйлдвэрлэдэг аж ахуйн чанарын түвшинг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Төслийн хүрээнд байгаль орчныг хамгаалах талаар зохистой менежментийг нэвтрүүлэн байгаль орчин хамгаалах арга аргачлалыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна.

“МӨНХИЙН БАЯН ГАЛ” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багын нутаг дэвсгэрт байрлан цемент үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлж байгаа билээ. Тус компани Монгол улсын холбогдох хууль журмын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчлалсан үнэлгээ ( БОНБНУ ) -г төслийн үе шатанд итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж, тэдгээрийн зөвлөмж заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба мөн байгаль орчны хууль журмын дагуу 2 жил тутам байгаль орчны аудитыг итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар хийлгэн уг аудитаар гарсан заавар, зөвлөмжийг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.

## 1. “МӨНХИЙН БАЯН ГАЛ” ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. Төслийн ерөнхий мэдээлэл

#### 1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг захиргааны харъяалал

Мөнхийн баян гал цементийн үйлдвэр нь Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутагт Улаанбаатар хотоос урагш 64 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 31 км, Сэргэлэн сумаас зүүн тийш 22 км, Налайхаас урагш 23 км-т Сэргэлэн сумын 1-р багийн нутагт, Төмөр замын 7 дугаар зөрлөгөөс урагш / хуучин орос цэргийн ангийн хойно / салаа төмөр замын далан дагуу цахилгаан дэд станц хүртлэх нутагт нийт 108 га талбайг хамарч оршино.



Зураг.1 Байгууламжийн ерөнхий бүтэц зохион байгуулалт

### 1.2 Үйлдвэрийн байгууламжийн ерөнхий бүтэц зохион байгуулалт:

Үйлдвэрийн үйл ажиллагаа явагдаж буй талбайн хүрээгээр 107.93 га эдэлбэр газар хамрагдаж байна. Эдэлбэрийн төв хэсэгт орших үндсэн барилга дотор үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагддаг ба технологийн цехүүд, түүхий эд болон бэлэн насосны станц, авто гараж, засвар механикийн хэсэг, цэвэрлэх байгууламж, лаборатори, уурын зуух, оффис, ажилчдын амрах байр, цайны газар, хүлэмж зэрэг хэд хэдэн жижиг барилгуудыг ашигладаг.



Зураг.2

Эдэлбэр газарт байрших барилга объектууд:

Түүхий эд, материалын агуулах,

Үйлдвэрийн барилга

Удирдлагын өрөө, химийн бодисын агуулах, лабораторийн барилга

Халаалтын зуухны барилга

Оффис, ажилчдын амрах байр

Ажилчдын цайны газар

Засвар механикийн цех

Бэлэн бүтээгдэхүүний агуулах гэх мэт объектуудаас бүрдэнэ.

Лаборатори:

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс дээж сорьц авч физик механик шинж чанарыг

тодорхойлох

зориулалттай.

Ус хангамж, ариутгах татуурга

Өөрийн нутаг дэвсгэрт өрөмдөж гаргасан гүний худгийн эх үүсвэрээс усны хэрэгцээг хангадаг. Технологийн хэрэглээнээс бохир үүсэхгүй.

Ахуйн хэрэглээнээс үүсэх бохир усыг цэвэршүүлэн зайлуулах 2 хэсэг байгууламж

байгуулж ашиглаж байгаа боловч байгаль цаг уурын нөхцөлд ажиллах боломжгүй байгаагаас үүдэн ашиглалтыг зогсоосон. Ахуйн бохир усыг үйлдвэрийн нутагт үүсгэсэн хүнхээл санд хуримтлуулдаг. Хаягдал усны санг харстэй шууд харьцах байдлаар байгуулсан.

Технологи

Үндсэн технологи нь дараахь шат дамжлагуудыг дамжина.

Үүнд:

Түүхий эд /шохойн чулуу, шар шороо, нүүрсний үнс, төмрийн баяжмал, гөлтгөнө, цеолит, байгалийн шохой, түлшний нүүрс/- ийг тээвэрлэх, агуулах

Түүхий эдийг бутлах, нунтаглах

Түүхий эдийг бүтээгдэхүүний чанараас хамааруулан дозлох, янз бүрийн харьцаагаар хольж нэгэн төрлийн болгох

Эргэдэг зууханд түүхий эдийг кальцжуулах ба шатаах

Клинкерийг хөргөх ба түүнийг гөлтгөнө, цеолит, байгалийн шохойтой холих

Хольсны дараа цементийг нунтаглах, хадгалах, савлах, тээвэрлэх зэрэг хамаарна.

Үйлдвэрлэлийн технологийн шугамын товч танилцуулга

### 1.3 Үйлдвэрийн тоон мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлт
1	Аж ахуй нэгжийн нэр	“Мөнхийн баян гал” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	9019024058
3	Регистрийн дугаар	5118115
4	Төслийн нэр	Цемент боловсруулах үйлдвэр
5	Газар ашиглах гэрчилгээний дугаар	№0000124341
6	Газар ашиглах шийдвэрийн дугаар	Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2022 оны 10 дүгээр сарын 10-ний өдрийн А/1126 тоот шийдвэр
7	Газрын хэмжээ	108 га
8	Газар ашиглах зориулалт	Үйлдвэрлэл
9	Үйлдвэрлэх түүхий эд	Портланд цемент
10	Жилд үйлдвэрлэх хүчин чадал	1 сая тонн
11	Газрын байршил	Төв аймаг Сэргэлэн сум 1 дүгээр баг
12	Үйл ажиллагаа эхэлсэн он	2015 ОН
13	Одоогийн байдал	2023 оны байдлаар Үйлдвэрийн үйл ажиллагаа улирлын хугацаандаа хэвийн ажилласан.
14	Түүхий эд	Шохойн чулуу, шар шороо, төмрийн баяжмал, байгалийн шохой, гөлтгөнө, цеолит, нүүрсний үнс
15	Ажиллах горим	03 дүгээр сараас 11-р сарын дунд хүртэл

**1.4 Үйлдвэрлэлийн хүчин чадал мэдээлэл**

Цементийн үйлдвэр нь жилд 1 000 000 тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд үүний 200 000 тонн нь P.C 32.5 маркийн холимог цемент, үлдсэн 800 000 тонн нь P.O 42.5 маркийн ердийн цахиурын исэлтэй цемент үйлдвэрлэх хүчин чадалтай.

**Хүснэгт 1. Үйлдвэрийн газрын барилга байгууламжийн эзлэх талбайн гол үзүүлэлтүүд**

Стандартын нэр	Хэмж. нэгж	Тоо хэмжээ
Үйлдвэрийн эзлэх талбай	м <sup>2</sup>	326 830
Барилга байгууламжийн эзлэх талбай	м <sup>2</sup>	34 200
Түүхий эд хураах талбай	м <sup>2</sup>	59 000
Бэлэн бүтээгдэхүүн хураах талбай	м <sup>2</sup>	21 000
Үйлдвэр дотоод авто замын нийт урт	м <sup>2</sup>	6 500
Автозамын эзлэх талбай	м <sup>2</sup>	28 960
Ногоон байгууламж	м <sup>2</sup>	32 000
Хөдөлгөөн хийх хатуу хучилттай талбай	м <sup>2</sup>	10 328

**Хүснэгт 2. Үйлдвэрийн ажиллах хүчний үзүүлэлт**

№	Ажлын байр	Нийт ажиллагсдын
	А. Үйлдвэрийн тасаг	
		<b>1</b>
1	Контор	5
2	Төвийн хяналтын өрөө	1
3	Түүхий эд бэлтгэх болон хаягдал хий арилгах	4
4	Шатаалт	3
5	Бэлэн бүтээгдэхүүн хадгалах болон тээвэрлэх	1
6	Цемент хийх болон тээвэрлэх	6
	Б. Бусад ажил	<b>2</b>
1	Цахилгаан хангах	1
2	Ус гадагшуулах болон уурын зуух, эргэлтийн насос станц шалгагч, сантехникч	7
	Нийт	<b>2</b>


**Хүснэгт 3. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжүүд**

№	Машин, тоног төхөөрөмжийн нэр	Марк, төрөл	Тоо	Хүчин чадал
1	Шохойн чулуу бутлагч	TKLPC 20.22E	1	60тн/цаг
2	Шохойн чулуу нунтаглагч	MLS3626	1	190 тн/цаг
3	Шатаах систем, нам даралтын 5-р зэргийн халаалтын төхөөрөмж, NDF задлах зуух	NDF	1	Голч 4 м, урт 60 м
4	Хөргөлтийн аппарат			
5	Түлшний нүүрс нунтаглагч	HRM 1400	1	18-22 тн/цаг
6	Цемент нунтаглагч	HFCG 150-100	2	110-120 тн/цаг
7	Цемент савлах машин /8 хошуутай/		4	90-100 тн/цаг
8	Хий шахагч станц /4 компрессор/			40 м <sup>3</sup> /мин, 0,8

"Мөнхийн баян гал" ХХК-ийн Цементийн үйлдвэр нь хуурай аргын технологитой бөгөөд энэ нь нойтон аргатай харьцуулахад эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай аргад тооцогддог. Тус үйлдвэр нь хоногт 2500 тонн цементийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ хатаалтын технологийн шинэ аргачлалтай. Гэхдээ хуурай технологийн аргын дутагдалтай тал нь бутлах, нунтаглах үеийн буюу үрэлтээс үүссэн тоосжилттой байдаг байна. БНХАУ-ын Улаан цемент корпораци нь “Мөнхийн баян гал” ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулагч бөгөөд уг корпорацийн Монгол дахь салбарын цементийн үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа нь доорхи үе шаттайгаар явагдана /зураг харна уу/. Үүнд:

- Түүхий эд /шохойн чулуу, шар шороо, нүүрсний үнс, төмрийн баяжмал, гөлтгөнө, цеолит, байгалийн шохой, түлшний нүүрс/- ийг тээвэрлэх, агуулах
  - Түүхий эдийг бутлах, нунтаглах
  - Түүхий эдийг бүтээгдэхүүний чанараас хамааруулан дозлох, янз бүрийн харьцаагаар хольж нэгэн төрлийн болгох
  - Эргэдэг зууханд түүхий эдийг калыцжуулах ба шатаах
  - Клинкерийг хөргөх ба түүнийг гөлтгөнө, цеолит, байгалийн шохойтой холих
- Хольсны дараа цементийг нунтаглах, хадгалах, савлах, тээвэрлэх


### Үйлдвэрийн технологийн бүдүүвч



Зураг.3 Үйлдвэрлэлийн ерөнхий схем



Үйлдвэрлэлийн технологийн шугамын товч танилцуулга



Зураг.4 Үйлдвэрлэлийн ерөнхий бүдүүвч

**1.5 БОННУ-ний тайлан**

Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт орших Мөнхийн баян гал цементийн үйлдвэр нь тусгай зөвшөөрлийн дагуу боловсруулах үйлдвэрийн холбоотойгоор Монгол улсын хуулийн дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчлалсан үнэлгээг /БОНБНУ/ 2008, 2016, 2022 онуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчлалсан үнэлгээтэй уялдуулан боловсруулж сум орон нутгийн захиргаа Байгаль орчин аялал жуулчлалын яамаар хянуулан ажиллаж байна.

№	Цементийн үйлдвэр	Байгаль орчны ерөнхий үнэлгээ	Байгаль орчны нарийвчлалсан үнэлгээ
1	Боловсруулах үйлдвэр	2008/A127	Текол ХХК
2		2015/B008	Итгэлт бээс ХХК
3		2021/OA97	Ойт бүс ХХК

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд үйлдвэрийн тус бүрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд туссан болзошгүй болон, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллаж байна. Тус компани нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаатай холбогдуулан байгаль орчны удирдлагын зохистой менежментийг бий болгон жил бүр сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

**2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**



Манай үйлдвэрийн гол зорилго нь орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, шинэ арга, техник технологиор стандартын техникийн шаардлагад нийцсэн цемент үйлдвэрлэж, эх орны бүтээн байгуулалтыг цементээр бүрэн хангах зорилготой. “Мөнхийн баян гал” ХХК болон гэрээт компаниудад байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зааж чиглүүлэх үндсэн зорилготой юм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтууд нь гэрээт байгууллагын гэрээ нь хуулийн бусад шаардлагатай зөрчилдөх болбол гэрээ болон хуулийн шаардлагыг баримтлал болгоно.Тус БОМТ-нд тодорхойгүй элементүүд болон байгаль орчинд аюул эрсдэлтэй үйл ажиллагаа хийх гэж байвал хэрэгжүүлэхээс нь өмнө Мөнхийн баян гал ХХК тодруулга авна.

Мөнхийн баян гал ХХК болон гэрээлэгч байгуулагууд тус байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой. Үүнд:

1. Байгаль орчны хуулийн нийцлийг хангах (жагсаалт хавсралт )
2. Нарийвчласан үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр тодорхойлох үнэлэлт дүгнэлт өгөх
3. Мөнхийн баян гал ХХК байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх

Бүтээн байгуулалтад байгалийн баялагыг зүй зохистой ашиглана.

Ус, агаар, биологийн олон янзын байдал хог хаягдал газар зохион байгуулалт зэрэг чиглэлээр олон янзын үйл ажиллагаа хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэн Монгол улсын байгаль орчны тухай хуулийг ёсчлон дагана.

Бид явуулж буй үйл ажиллагаанаасаа байгаль орчинд учруулах нөлөөллийг бууруулах,арилгах цаашилбал байгаль орчны өндөр стандартыг тогтоож, орон нутгийн ард иргэдийн санал зөвлөгөөг үйл ажиллагаандаа тусгах болно.

Байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх Үйлдвэрлэлийн онцлог давуу тал Хуурай аргын буюу байгаль орчинд ээлтэй шинжлэх ухаан технологийн сүүлийн дэвшилтэт ололтыг бүрэн нэвтрүүлсэн Үйлдвэрийн цех дамжлагууд бүрэн автоматчлагдсан. Тоосжилтын хэмжээ болон хүлэмжийн хийн ялгаруулалт маш бага Ус, Эрчим хүч түлшний хэмнэлттэй. Байгаль орчинд сөрөг нөлөө бага эко үйлдвэр.

#### **Байгаль орчны зөв менежмент**

Байгаль орчны хяналтын тогтолцоо

Монгол улсад өрнөж буй бүх нийтийн байгаль орчны уриалгад нэгдэх

Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх

Байгаль орчны хор хөнөөлөөс ангид байх

Унаган төрхөөр нь хамгаалах

“Мөнхийн баян гал” цементийн үйлдвэрийн 2023 оны 4-р улирал буюу жилийн эцсийн байдлаар үйлдвэрийн бүтээгдэхүүний мэдээлэл

№	Түүхий эдийн зарцуулалтын мэдээлэл	1 жилийн хэрэглээ
1	Шохойн чулуу	472.000
2	Гөлтгөнө	27.000
3	Төмрийн хүдэр	44.000
4	Улаан шавар	59.000
5	Үнс	22.000тн
Цемент үйлдвэрлэлийн тоон мэдээлэл		
1	Цемент	392.000тн
2	Чулуунцар	356.000 тн

---ooOOOOOoo---

### 3. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Богино хугацааны нөлөөлөл** Тээрэм бутлуур, шатаах зуух зэрэг хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах, хөрс бохирдох, мөн цементийн түүхий эд болох хөрс чулуулагууд ачих тээвэрлэх явцад тоос босох, дуу чимээ гарах зэрэг сөрөг нөлөөллүүд нь богино хугацааны нөлөөлөлд багтана. Түүнчлэн хур бороо багатай агаар хуурайшсан салхитай үед хөрсний овоолго зам тээврээс их хэмжээний органик бус тоос ялгарч ажиллагсдын эрүүл мэнд болоод хүрээлэн буй орчны хөрс ургамалд нөлөөлнө.

**Урт хугацааны нөлөөлөл** Түүхий эд олборлох, тээвэрлэх явцад байгалийн унаган төрх алдагдаж, хөрс ургамлын бүтцэд өөрчлөлт орж элэгдэл эвдрэлд оруулах зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг дэс дараалалтай хийж хэвших нь хүрээлэн буй орчны цаашдын насжилтанд маш чухал юм.

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
	Нөлөөгүй	Муу	Дунд	Сайн
<b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>				
Голын голдиролыг эвдэх, өөрчлөх, эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх	x			
Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах	x			
Ой модыг огтлох явдал гарах	x			
Түүх соёлын дурсгалт газрыг эвдэхэд хүрэх	x			
Усан хамгамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	x			
Бүс нутгийн булаг, шанд хатах, ширгэх аюул гарах эсэх	x			
Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх				x
<b>2. Цементийн үйлдвэрийн төслийн шийдэл, төлөвлөлттэй холбоотой байгаль орчны асуудал</b>				
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс сэргийлэн хамгаалах болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудлыг төлөвлөлт			x	
Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагааны үед гарах шуугианыг тогтоосон хэмжээнээс				x
Тусгай анхаарал тавих шаардлагатай цацраг идэвхит бодис, тоос, утаа гардаг эсэх			x	
<b>3. Төслийн үйл ажиллагааны үеийн байгаль орчны асуудал</b>				
Үйлдвэрийг барих ба ашиглах үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x	
Хөрсний элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд тусгагдсан байдал (нүхийг буцааж битүүлэх, хөрсжүүлэх ургамал тарих)		x		
Үйлдвэрийн технологийн болон ахуйн бохир усыг цэвэрлэлгүйгээр хаясанаас хөрсөнд нэвчин хөрсний болон гүний ус бохирдох, улмаар усны гольдиролд сөрөгөөр нөлөөлөх		x		
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан )		x		
Төслийн бусад асуудал (төслийн инженерийн болон санхүү, эдийн засгийн боломжийн талаарх асуудал)			x	
<b>4. Төслийн ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)</b>				
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад олдосгүй нөөц баялагыг зөвтгөх аргагүйгээр гарздах	x			
Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх (генофондод нөлөөлөх, ховор, нэн ховордсон амьтан ургамал устгах г.м )	x			

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

##### 4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
1	Тоосжилт, дуу шуугиан үүсэж, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх явцад хариу арга хэмжээ авах	Дуу чимээ, тоосжилттой ажлын байранд ажиллах ажиллагсдыг маск, иж бүрэн хувцас, чихний бөглөө, нүдний шил зэрэг хамгаалах хувцас хэрэгслээр хангах	100%
2	Тоосжилт бууруулах зорилгоор үйлдвэрийн түүхий эд болон, цемент тээвэрлэх засмал замаас үйлдвэр хүртлэх сайжруулсан шороон замыг усалгаа арчилгааг хийж, зорчиж буй автомашинд хурдны хяналт тавих	Үйлдвэр орчимд техникийн нөлөөллөөс шалтгаалах тоосжилтыг бууруулах хариу арга хэмжээний хүрээнд шинэ усалгааны машиныг өдөр бүр хуурайшилттай үед хийж хэрэгжүүлж ажиллаж байв.	100%
3	Үйлдвэрлэлийн хэсэгт тоосжилтийн гаралт хэмжээ тодорхойлж тоос болон тоосонцорын үзүүлэлтүүдийн түвшинг тодорхой давтамжтайгаар, сонгосон цэгүүд дээр хэмжилт хийнэ.	Үйлдвэрлэлийн орчин болон, Ажилчдын эрүүл ахуйн үүднээс мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж ажилласан бөгөөд, ажилтан бүрт тусгай тоос шүүх аппаратыг зүүлгэн цагын давтамжтай хянаж ажиллав.	100%

##### 4.1.1 Тоосонцорын агууламжийн хэмжилт

“Мөнхийн баян гал” ХХК-ийн ажлын байранд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт судалгааг 56 ажлын байранд 14 төрөл (агаарын температур-174, агаарын харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурд, гэрэлтүүлэг, шуугиан, гарт дамжих эргономик, гарт дамжих доргион, бүх биед дамжих доргион цулцанд нэвтэрдэг тоос, цахиур агуулсан тоос, угаарын хий) эргономик -ийн хэмжилтийг ашигласан болно.

##### 4.1.2 Ажлын байран дахь хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн үзүүлэлт, стандарт арга аргачлал

Ажлын байрны сөрөг хүчин зүйлсийн талаарх мэдээллийг чанарын аргаар тодорхойлож, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийх үзүүлэлтүүдийг тодорхойлов. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд сонгосон үзүүлэлтүүдийг харуулав. Үүнд:

1. Эргономик (ажлын байранд)
2. Температур, чийглэг (ажилтан, ажлын байранд)
3. Бүх биед дамжих доргион (ажлын байранд)
4. Гарт дамжих доргион (ажлын байранд)
5. Гэрэлтүүлэг (ажлын байранд)
6. Цахилгаан соронзон орны хүчдэл (ажлын байранд)

7. Цулцанд нэвтэрдэг тоос (ажилтны амьсгалын түвшин)
8. Кварц цахиур агуулсан тоос (ажилтны амьсгалын түвшин)
9. Хүнд металл (ажилтны амьсгалын түвшин)
10. Шуугианы өртөлт (ажлын байранд, талбайд)
11. Агаарын урсгалын хурд (ажлын байранд)
12. Гарт дамжих эргономик

#### 4.1.3 Ажлын байран дахь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хэрэгжүүлсэн үе шат, аргачлал огноо

1 <sup>Ч</sup> БМ	1*	Аргачлал, хэрэглэгдэхүүн	Үр дүн
Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний түвшин тодорхойлогдсон үзүүлэлтүүдээр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх (2023.09.07-08)		Ажлын байран дахь сөрөг хүчин зүйлсийн өртөлтийн түвшнийг тодорхойлсон: <ul style="list-style-type: none"> <li>• Агаарын температур, харьцангуй чийглэг</li> <li>• Агаарын урсгалын хурд</li> <li>• Гэрэлтүүлэг</li> <li>• Ерөнхий шуугиан</li> <li>• Цахилгаан соронзон орны хүчдэл</li> <li>• Эргономик</li> <li>• Асуумж судалгаа</li> <li>• Гарт дамжих доргион</li> <li>• Бүх биед дамжих доргион</li> <li>• Цулцанд нэвтэрдэг тоос</li> <li>• Кварц агуулсан тоос</li> <li>• Нүүрстөрөчийн дутуу исэл</li> <li>• Хүнд металл</li> <li>• Гарт дамжих эргономик</li> <li>• Биеийн хүчний эргономик</li> </ul>	Ажлын байран дахь хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт: <ul style="list-style-type: none"> <li>• Агаарын температур, харьцангуй чийглэг</li> <li>• Агаарын урсгалын хурд</li> <li>• Гэрэлтүүлэг</li> <li>• Ерөнхий шуугиан</li> <li>• Цахилгаан соронзон орны хүчдэл</li> <li>• Эргономик</li> <li>• Асуумж судалгаа</li> <li>• Гарт дамжих доргион</li> <li>• Бүх биед дамжих доргион</li> <li>• Цулцанд нэвтэрдэг тоос</li> <li>• Кварц агуулсан тоос</li> <li>• Нүүрстөрөчийн дутуу исэл</li> <li>• Хүнд металл</li> <li>• Гарт дамжих эргономик</li> <li>• Биеийн хүчний эргономик</li> </ul>
Ажлын байрны эрсдэлийн үнэлгээний түвшин дээр тодорхойлогдсон одоогийн эрсдэлийн түвшинд үндэслэн Хөдөлмөрийн нөхцөлийг ангилал (2023 09.07-08)		<ul style="list-style-type: none"> <li>• Ижил өртөлтийн бүлэг тус бүрийн Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлд суурилсан үнэлгээний дүн</li> <li>• Хими, физикийн хэмжилтүүдийн эрөдэлийн үнэлгээний дүн Хөдөлмөрийн эрүүл мэндийн нэмэлт мэдээлэл</li> </ul>	Ажлын байрнуудын хөдөлмөрийн нөхцөлийн ангилал тодорхойлох
Дүгнэлт, Зөвлөмж боловсруулах,тайлан хэвлүүлэх		Хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс сэргийлэхэд чиглэсэн зөвлөмж	Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн дүн Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал

## Түүвэрлэн шинжилгээний үр дүнг оруулав.

Ажлын байрлал	Ажлын нэршил	Ажлын тодорхойлолт	Ажлын “ ” гүйцэтгэх үйлдүүд	Эргономикийн эрсдэлт хүчин зүйл
Оффис	I Төв удирдлагын I оператор	Дэлгэц бүхий тоногт төхөөрөмжийн удирдах самбар хянах	Дэлгэц бүхий тоногт төхөөрөмжийн удирдах самбар хянах	Олон дахин давтагдах хөдөлгөөн + нүдний хараа +

1. Тээрийн оператор ажлын байран дахь хүчин зүйлсийн өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн түвшин

## Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн дүн, ажилтны эрүүл мэндийн эрсдэлийн түвшин

Улирлын чанартай эсэх Үгүй	Хэмжилт хийсэн байрлал Оффис	Ажлын байрны талбай хэмжээ хангалттай	Ашигладаг болон өртөж буй химийн бодис, бусад хүчин зүйл Тийм	Хэмжилтийн статистик утга			
Ажлын байрны эрсдэлт хүчин зүйл	Хамгийн бага ихутга	Арифметик дундаж	Геометр 90%-ийн дундаж ИДХ	ЗХД-ээс хэтэрсэн хувь	ЗДХ	Эрсдэлийн түвшин	
Агаарын температур (°C)	1 19.2-21.6	20.4		0%	18-27	Эрсдэлгүй	
Агаарын харьцангуй чийглэг (%)	1 30.0-31.4	30.7		0%	30-60	Эрсдэлгүй	
Агаарын хөдөлгөөний хурд, (м/сек)	1 0.0	0.0		<	0.2<	Дунд	
Ерөнхий Гэрэлтүүлэг (лк)	1 600-642	621		0%	300	Эрсдэлгүй	
Ерөнхий шуугиан (ДБА)	1 76.8-80.6	78.7		0%	85	Эрсдэлгүй	
Гарт дамжих доргион (м/с <sup>2</sup> )	1 2.9	2.9		0%	5.0	Эрсдэлгүй	
Цулцанд нэвтэрдэг тоос (мг/м <sup>3</sup> )	1 23.84	23.84		11.9 дахин их	2.0	Өндөр	
Кварц цахиур тодорхойлох (мг/м <sup>3</sup> )	1 1.66	1.66		23.7 дахин их	0.07	Өндөр	

Гарт дамжих эргономикийн үнэлгээ


Ажлын байрлал	Ажлын нэршил	Ажлын тодорхойлолт	Ажлын цаг	Гүйцэтгэх үйлдүүд	Эргономикийн эрсдэлт хүчин зүйл
Цементийн үйлдвэр	Тээрийн ахлах	Хяналт тавих	8	үзлэг шалгалт хийх, шаардлагатай тохиолдол засвар үйлчилгээ хийх	Албадмал байрлал + Олон дахин давтагдах хөдөлгөөн + Хүч зарцуулалт + Температур +

2. Зуухны оператор ажлын байран дахь хүчин зүйлсийн өртөлтөөс хамаарсан эрүүл мэндийн эрсдэлийн түвшин

## Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн дүн, ажилтны эрүүл мэндийн эрсдэлийн түвшин


Улирлын чанартай эсэх Үгүй	Хэмжилт хийсэн байрлал Оффис	Ажлын байрны талбай хэмжээ хангалттай	Ашигладаг болон өртөж буй химийн бодис, бусад хүчин зүйл Үгүй	Хэмжилтийн статистик утга			
Ажлын байрны эрсдэлт хүчин зүйл	Хамгийн бага их утга	Арифметик дундаж	Геометр 90%-ийн дундаж ИДХ	ЗХД-ээс хэтэрсэн хувь	ЗДХ	Эрсдэлийн түвшин	
Агаарын температур (°C)	1 9.5-12.3	11.0		<	18-27	Эрсдэлгүй	
Агаарын харьцангуй чийглэг (%)	1 29.7-30.4	30.0		0%	30-60	Эрсдэлгүй	





*Зураг.5 Орчны цахиур болон цулцангын тоосжилт хэмжих буй байдал*

Орчны хяналт шинжилгээний болон Цулцанд нэвтэрдэг тоос тоосонцорын хэмжилтийг ажилчдад тус бүрт нь зүүж, мөн орчны тоосонцорыг үйлдвэрлэлийн объект бүр дээр нь эрх бүхий мэргэжлийн байгууллага хэмжиж буй байдал



*Зураг.6 Агаарын харьцангуй чийглэг (% тоосжилт хэмжих буй байдал*

#### 4.2. Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт

2023 оны байгаль орчны төлөвлөгөөний тоосжилт бууруулах ажлын хүрээнд тоосжилт ихээр үүсгэж буй хатуу хучилттай засмал замаас үйлдвэр хүртлэх замуудад хайрга дэвсэх, хусах, замын усалгаа арчилгааг нэмэгдүүлэх, сайжруулах зэрэг арга хэмжээг улирал бүр авч ажилласан бөгөөд, усалгааг тоосжилттой үед өдөр бүр усалгаа хийж ажиллав.



Зураг.7 Усалгаа хийж буй байдал

##### 4.2.1 Түүхий эд татан авалт, бүтээгдэхүүн тээврийн үйл ажиллагаанаас үүсэх тоос тоосонцор

№	Төслийн үйл ажиллагааны төрөл	Ялгарлын хэмжээ, тн/жил		
		Нийт тоос	PM10 тоосонцор	PM2.5 тоосонцор
1	Түүхий эд татан авах тээврийн үйл ажиллагаа	706.2	239.4	23.9
2	Түүхий эд буулгах	9.2	3.3	0.7
3	Үйлдвэрийн элэгдэлд орсон талбайн салхины элэгдэл	18.8	9.4	1.4
4	Бүтээгдэхүүн тээвэрлэлт	252.2	85.5	8.6
<b>Төслийн үйл ажиллагаанаас жилд үүсэх тоос тоосонцрын хэмжээ, тн</b>		<b>986.4</b>	<b>337.6</b>	<b>34.6</b>


Энэхүү үзүүлэлтээс харахад байгалийн хур тунадас болон замаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр тоосжилтыг 30% бууруулан гэж үзсэн ч нэгдсэн үр дүнгээс харахад тээврийн замаас үүсэх тоосны хэмжээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэж буй нийт тоос тоосонцрын 96 орчим хувийг дангаараа бүрдүүлж байна. Иймд үйлдвэрлэлийн хугацаанд сайжруулсан шороон замаас үүсэх тоосны хэмжээг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч, ажиллаж байна.

##### 4.2.2 Тоос хураах төхөөрөмж ба орчны хамгаалалт

Үйлдвэрээс гарах тоос тоосонцорын агаарт дэгдэхээс өмнө орчны хамгаалалт ба тоос шүүр системийг байрлуулж ажилласан бөгөөд энэ нь өндөр бүтээмжтэй, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд ээлтэй, бөгөөд хоргүй үйлдвэрлэлийн дэвшилтэд техник, технологи болон DCS хяналтын систем, сайн чанарын тоос цэвэрлэх

төхөөрөмжүүд зэрэг үйлдвэрлэлийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглаж байна.

Үйлдвэрийн тоос шүүх системийг доорх зурагт харууллаа.



Зураг.8 Тоос шүүх систем

Тоос, тоосонцор нь цементийн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад агаарыг бохирдуулах гол шалтгаан болдог. Тоос, тоосонцрыг арилгах нь цементийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад байгаль орчны тэнцвэрийг хадгалах гол үйл ажиллагаа юм. Тоос гарч байгаа цэгийг үр ашигтай хязгаарлахын тулд үйлдвэрийн явцад аль болохоор нягт битүүмжлэл өндөртэй тоног төхөөрөмж болон вакуум хэлбэрийн хадгалах агуулахууд сонгох, эд материалыг дамжуулан тээвэрлэх зайг багасгаж, тоосонцор бүхий хийг өндөр бүтээмжтэй тоос арилгагч /сорогч/ төхөөрөмжөөр цэвэрлэн ариутгаж, стандартын шаардлага хангасан нөхцөлд ялгарсан хийг хүрээлэн буй орчинд ялгаруулан хаях ёстой.

Тоос шүүх уутан хэлбэрийн шүүлтүүрүүд нь үйлдвэрлэлийн түүхий эдийн нунтаглах технологи мөн савалгааны хэсэг болон тоос тоосонцор үүсэх бүхий л хэсэгт байрлагддаг бөгөөд түүнээс гарах филтерийг тогтмол солиж, арчилгаа үйлчилгээ хийж ажилладаг.



Зураг 9. Тоос сорох, хураах төхөөрөмжүүдийн зарим хэсэгт байгаа байдал

### 4.3 Усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн тодорхойлолт товч	Биелэлтийн хувь
1	Гадаргын болон гүний ус бохирдох	Бохир ус цэвэрлэгээний байгууламжийн үйл ажиллагааг хэвийн горимд үе шаттай шилжүүлэх, гүний болон хаягдал усны чанарын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	100%
2	Байгалийн усны нөөцашиглах, хамгаалах	Усны нөөц ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	100%
3	Ус ашиглалтын талаар усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд тусгай зөвшөөрөл хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Усны тухай хууль тэдгээртэй холбогдсон харилцааны хүрээнд бүх төрлийн гэрээ зөвшөөрлийг зохих цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаж байв.	80%

#### 4.3.1 Суурьшлын бүс ба үйлдвэрийн ахуйн бохир усыг цэвэрлэх цэвэрлэх байгууламж Хаягдал ус цэвэрлэх технологи ба барилга байгууламж

Ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус нь сараалж 1-ээр орж том ширхэгтэй хог хаягдалаасаа цэвэрлэгдэх  $2.8 \text{ м}^3$  багтаамжтай хүлээн авах камер 2-т өгөгдөнө. Хүлээн авах камер дахь бохир усыг насосоор татаж,  $45 \text{ м}^3$  багтаамжтай жигдрүүлэх сан 3-руу түүний чанар хэмжээг тогтвортой байлгахын тулд шахна. Жигдрүүлэх сангаас мөн насосоор соруулж  $10 \text{ м}^3$  багтаамжтай анхдагч босоо тунгаагуур 4-рүү оруулна. Анхдагч тунгаагуураас хальсан ус  $14 \text{ м}^3$  багтаамжтай нитратгүйжүүлэх байгууламж 5 руу орох ба байгууламжийн доороос агаар үлээлгэж өгөхөд бохир усан дахь органик азотыг үгүй болгож, нитратгүйжүүлсэн усны доторх Nitro-N эсвэл Нитрозо-N /NO-N, NO-N/-ийг азотын хий /N/ болгон өөрчилнө.

Үүнээс цааш нитратгүй болсон ус  $20 \text{ м}^3$  багтаамжтай нэгдэх аэротенк руу, тэндээсээ  $13 \text{ м}^3$  багтаамжтай хоёр дахь аэротек руу өөрийн урсгалаар орно. Эдгээр аэротенкуудын дороос агаар үлээгүүр /компрессор/ 8-аар агаар үлээлгэж усыг аэрацад сайтар оруулна. Иймээс аэротенкийн байгууламж руу үлээлгэсэн агаарт байх хүчилтөрөгчийн үйлчлэлээр аэробны бактер эрчимтэй түргэн үржих, бохир усан дахь органик хольцыг исэлдүүлэх мөн хүчилтөрөгч нь усан дахь анаэробны буюу эмгэг өвчин үүсгэгч бактериудын амьдрах орчныг хааж өгнө. Ингээд сүүлчийн аэротенк дэх усыг насосоор соруулан авч 2 дахь тунгаагуур 7 руу шахна. Энд тунгалагжсан ус нь  $6.5 \text{ м}^3$  багтаамжтай завсрын сан 9-д өгөгдөнө.

Зураг 10. Цэвэрлэх байгууламжийн гадаад, дотоод байдал



Завсрын сан дахь усыг насосоор соруулан нүүрсэн шүүлтүүрийн төхөөрөмж рүү шахна. Шүүлтүүр нь усанд тунаагүй үлдсэн умбуур бодис болон бичил органик бодисыг шүүхээс гадна усны өнгө, үнэрийг арилгана.

Харин анхдагч ба хоёрдогч тунгаагууруудад тунасан лаг нь  $5\text{м}^3$  багтаамжтай лагийн сан 11-д өгөгдөн түр хуримтлагдах ба тодорхой графикийн дагуу түүнийг үйлдвэрийн захиргаа өөрсдөө гадагш тээвэрлэн орон нутгийн ЗДТГ-аас олгосон шингэн хаягдал цэгт хаяна.

Нүүрсгөрөгчийн шүүлтүүрээр цэвэрлэгдсэн усыг хлоржуулах төхөөрөмж 10-ын тусламжтайгаар ариутгаж, гэдэсний савханцар мэтийн эмгэг төрүүлэгч бактериудыг нь устгасны дараа  $12\text{м}^3$  багтаамжтай буцааж ашиглах усны сан 11-рүү өгнө. Энэ санд хуримтлагдсан саарал усыг насосын тусламжтайгаар ногоон байгууламжийн услалтын систем болон үйлдвэрийн лабораторийн барилгын 00-ын усны систем рүү шахах замаар тус тус ашиглахаар төлөвлөснөөс гадна саарал усны илүүдлийг үйлдвэрийн хашаанд байрлуулсан саарал усны санд хуримтлуулахаар төсөлд тусгасан. Гэсэн хэдий ч цаг уурын хэт хүйтэн нөхцөл байдлаас шалтгаалан ахуйн болон, үйлдвэрлэлийн хэсгийн цэвэрлэх байгууламж нь технологийн горимын дагуу ажиллах боломжгүй болсон учир эрх бүхий мэргэжлийн байгууллагаар соруулах арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд ирэх онд санхүүгийн нөөц бололцооноос шалтгаалан хэвийн горимд шилжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

#### 4.3.2 Мэргэжлийн байгууллагаар усны чанар судалгаа шинжилгээг хийлгэх

Ахуйн болон үйлдвэрлэлийн цэвэр бохир усны судалгаа шинжилгээг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгэж ажилласан бөгөөд орон нутгийн “Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборатор”-д, мөн “Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид тус тус шинжлүүлэн ажиллав.

/Зургаар харуулав. /

Зураг 11. Цэвэр, бохир усны шинжилгээг эх үүсвэр болон тунасан хэсгээс авч байгаа байдал



#### 4.4 Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
1	Үйлдвэрийн болон орчны талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг жилд 1-2 удаа явуулж, үр дагаврыг тогтмол хянах	70%
2	Ашиглалтын талбай дахь хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх	Эдэлбэр газрын хэмжээнд талбайн тохижилтыг хийж, ногоон байгууламж байгуулах	100%

##### 4.4.1 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар			
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их
1	Газар шорооны ажил гүйцэтгэх, инженерийн шугам татах			x	
2	Түүхий эд, туслах материалыг тээвэрлэх		x		
3	Санамсаргүй байдлаар шатах тослох материал хөрсөн дээр асгарах, хаягдсанаас ургамал гэмтэх, хордох	x			
4	Тээврийн хэрэгслээс ялгарах хорт угаа, шороо тоос салхиар дамжин ургамал, хөрсийг бохирдуулах		x		
5	Барилгын материалын хог хаягдал, үйлдвэрийн болон ахуйн бусад хаягдал ил задгай хаягдал хөрс, ургамлыг бохирдуулах		x		
	Нийт	1	3	1	
	Эзлэх хувь, %	20%	60%	20%	

Дүгнэлт: Үйлдвэрлэлээс ургамлан нөмрөгт үзүүлэх гол нөлөөлөл нь газар шорооны ажил, хог хаягдлаас үүдэлтэй. Төсөл хэрэгжих газар нь үйлдвэрийн бүсэд байрлах тул ургамлын төрөл зүйл хомс учраас төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл БАГА гэж дүгнэсэн байна.

#### 4.4.2 Эдэлбэр газрын хэмжээнд ногоон байгууламж байгуулах

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9.0%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлнэ гэсэн төлөвлөгөөний дагуу манай үйлдвэрийн хувьд энэ онд 3000 гаруй 2-3 настай улиас мод 2 га-д мэргэжлийн эрх бүхий байгууллага болох “Ногоон харш” ХХК-аар тариалалт болоод цаашидын ургалт арчилгааг хийж гүйцэтгүүлэхээр гэрээлэн ажиллаж байна.



Зураг 12. Үйлдвэрийн хашаа тойруулан мод тариалж байгаа байдал

#### 4.5 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөх

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
1	Тоос тоосонцор үүсгэж болохуйц үйлдвэрийн газрыг хатуу хучилттай болгох	Үйлдвэрийн түүхий хадгалах талбайн хэсгийг хатуу хучилттай болгож, хөрсөнд нэвчих болон агаарт дэгдэх тоосжилтийг багасгах	100%
2	Түүхий эд болон, цементийн тээврийн замын орчны тоосжилт үүсгэх	Зам талбайн тоосжилтын арчилгаа усалгааг цаг тухайд нь хийж хэвших	100%

##### 4.5.1 Түүхий эд талбайн хэсгийг хатуу хучилттай болгох

Цементийн тээрийн хэсэг болон, Төмрийн хүдрийн талбай, Шохойн чулууны талбайн баруун за хэсэгт хэсэгчилсэн цутгалтууд мэргэжлийн байгууллагаар 6647m<sup>2</sup> зам талбайг хийж гүйцэтгэв.



Зураг 13. Үйлдвэрийн түүхий эдийн талбайд болон савалгааны зорчих хэсгийн хучилт хийхийн өмнө байгаа байдал





*Зураг 14. Хучилт хийгдсэний дараах байгаа байдал*

#### **4.5.2 Тээврийн зам талбайн тоосжилтоос сэргийлэх бууруулах арга хэмжээ**

Тээврийн явцад гарах зарим тоосжилтын болон зам товчлох асуудалд Цемент худалдан авах болон, түүхий эд тээвэрлэж буй гэрээнд батлагдсан зам буюу засмал замаас үйлдвэр хүртэлх сайжруулсан шороон замаар заавал зорчих талаар тусгаж өгсөн бөгөөд, замыг засаж сайжруулсан тул зам товчлох гарц бүрд тэмдэг тэмдэглэгээг байршуулсан болон бороогүй хуурайшилттай өдөр бүр усалгаа хийж ажиллаж байна.

/Зам засвар болон усалгаа чийгшүүлж буй үйл явцын зургыг дээр харуулсан болно./



*Зураг 15. Тээврийн машинуудыг зориулалтын замаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулсан байдал*



Зураг 16. Зориулалтын бус зам товчлох хэсгийг хааж зогоон татсан байдал.

#### 4.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
1	Үйлдвэрийн болон орчны талбай дахь амьтны аймаг нөлөөлөлд өртөх	Амьтны мониторинг судалгааг жилд 1-2 удаа явуулж, үр дагаврыг тогтмол хянах	60%

##### 4.5.1 Амьтны мониторинг судалгаа хийх

Судалгааны арга зүй: Үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьтны судалгаа хийхэд тохиромжтой арга нь замналын арга байдаг бөгөөд энэхүү аргыг дүйцүүлэн хамгаалах газрын судалгаанд ашиглана. Замналын арга гэдэг нь автомашинаар газрын байдалд тохируулан тодорхой замнал /маршрут/-ын дагуу явж тааралдсан амьтдыг тоолж бүртгэхийг хэлдэг бөгөөд .Үнэг, туулай жигүүртэн гэх мэт амьтан 5 км-ээс бага зайд ойртоход үргэж дараагийн трансектийн бүс рүү орж давхар тоологдох магадлалтай болдог тул трансект хоорондын зайг 5 км-ээс багагүй байхаар амьтан тааралдах бүрд маягтын дагуу дэлгэрэнгүй бүртгэх ба дараах мэдээллийг тусгасан. Үүнд:

- Мониторинг хийж гүйцэтгэсэн ажилтны нэр
- Огноо
- Мониторинг хийж эхэлсэн, дууссан цаг
- Харьяалагдах засаг захиргааны нэр: аймаг, сум, баг
- Трансектийн дугаар
- Нийт харсан амьтны тоо
- Зүйлийн монгол нэршил
- Ажигласан цаг: Судалгааны явцад мэдээлэл цуглуулсан цаг, минутыг бичнэ
- Солбицол: зэрлэг амьтан тэмдэглэсэн тухайн цэгийн солбицлыг тэмдэглэнэ.

Төслийн талбай орчим нь антропоген нөлөөлөлд өртсөн учраас том хөхтөн амьтад

байхгүй, харин нүх ухаж орогнодог жижиг хөхтөн амьтад болон шавжийн ангийн зарим төлөөллүүд бий. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.



*Зураг 17. Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших амьтдын зураг*

## 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчлалсан үнэлгээний судалгаанд тусгасны дагуу үйлдвэрлэлийн орчимд ямар нэгэн түүх археологийн дурсгал илрээгүй, мөн хөрсний хувьд намаг цэвдэг бүхий бамбалзуур хөрстэй палеонтологийн талаас нөлөөлөх зүйлгүй гэж тогтоогдсон.

**А. Археологийн судалгаа.** Цементийн үйлдвэрийн орчим нь улсын чанартай авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам зэрэгт холбогдсон дэд бүтэц сайтар хөгжсөн бүс нутаг бөгөөд эртнээс эхлэн хүн тасралтгүй орших амьдарч байсан нутаг учир эртний түүх, археологийн хайгуул судалгааны ажил хийгдээгүй учир Монгол улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалттай түүх, археологийн томоохон дурсгал бүртгэгдээгүй байна. Иймд түүхийн олон үеийн дурсгал байх магадлалтай хэдий ч уг газар нь намагтай, цэвдэг бүхий бамбалзуур хөрстэй байгаа нь дурсгал байх магадлалыг багасгаж байна. Судалгааны үр дүнд ямар нэгэн түүх археологийн дурсгал илрээгүй болно.

**Б. Палеонтологийн судалгаа.** Төсөл хэрэгжих талбайд явуулсан палеонтологийн хайгуул, тандан судалгааны үр дүнд палеонтологийн олдвор эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илрээгүй болно. Гэсэн хэдий ч энэ талбайд тархсан девоны настай Горхи формацын улаан хасын үеүд нь микро амьтны үлдэгдэл радиолар элбэгтэй бөгөөд түүнд силур-девоны цаг үеийн радиоларын 4 цогцолборыг ялгаж, хурдсын насыг нарийвчлан тогтоож байсан стратиграфийн ач холбогдолтой зүсэлтүүдтэй дүүрэгт тус цементийн үйлдвэрийн талбай

хамаарагддаг тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Бидний судалгаагаар одоогоор цементийн үйлдвэр нь доод девоны Сэргэлэн формацын ногоон занарын зузаалаг дээр байрлаж байгаа нь тогтоогдсон тул палеонтологийн талаас нөлөөлөх зүйлгүй юм.

## 6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу химийн хорт бодис үйлдвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх аливаа төсөл нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд эрсдлийн үнэлгээ хийлгэсэн байх шаардлагатай. Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээний зорилго нь төслийн үйл ажиллагаанаас болон төсөл хэрэгжих явцад үүсэж болох осол, аюулын үед ялгарах химийн бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болох эрсдлийг үнэлэн тодорхойлж, тэдгээрээс гарах үр дагавар, түүнийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход оршино.

“Мөнхийн баян гал” ХХК-ийн “Цементийн үйлдвэр барих” төслийн дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх химийн бодисын эрсдлийн үнэлгээг “Химийн хорт ба аюултай бодисын тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиудад заасны дагуу Байгаль орчны

нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийж гүйцэтгэв. Эрсдлийн үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны А-50/378/565 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх аргачлалын” -ын дагуу гүйцэтгэсэн болно.

Эрсдлийн үнэлгээ нь хүний эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ (ХЭМЭҮ), байгаль орчны эрсдлийн үнэлгээ (БОЭҮ), осол, аюулын эрсдлийн үнэлгээ (ОАЭҮ) гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэж байгаа бөгөөд дээрх аргачлалд тусгагдсан ерөнхий зарчим, арга зүйг баримтлан эдгээр эрсдлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Хүний эрүүл мэндийн эрсдлийн ба Байгаль орчны эрсдлийн үнэлгээг хийх арга зүй нь ерөнхийдөө ижил байх бөгөөд хүн болон экологийн хүлээн авагчид бохирдолд ямар замаар өртснөөс эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болохыг үнэлэхэд чиглэгддэг. Харин осол, аюулын эрсдлийн үнэлгээ нь байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болох аюул, ослын магадлал, давтамж, хүчийг тогтоож, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөд учруулж болох хохирол, сөрөг нөлөөллийг үнэлэх зорилготой байдаг.

Энэхүү үнэлгээнд дор дурьдсан зүйлсийг хамруулаа. Үүнд:

- Химийн хортой болон аюултай бодисын нөлөөллөөс үүдэн бий болох эрсдлийг тодорхойлох;
- Эрсдлийг бууруулах болон арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;
- Хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулах;

- Эрсдлийн хор хөнөөлийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах;
- Осол аюулын үед авч хэрэгжүүлэх хоргүйжүүлэн саармагжуулах арга хэмжээ авах аргачлал боловсруулах

“Мөнхийн баян гал” ХХК-ийн “Цементийн үйлдвэр барих” төсөл нь дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаандаа 48 нэрийн химийн бодис ашиглах тул эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн үнэлгээг хийх зайлшгүй шаардлага тулгарсан юм.

Аливаа химийн бодисын физик-химийн ангилал нь тухайн бодисын тэсрэмтгий, шатамхай, мөн хүчилтөрөгчтэй исэлдэх шинж чанар дээр үндэслэгдсэн байдаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 04/04 тоот хамтарсан тушаалын 1 дугаар хавсралт ёсоор химийн аюултай бодисын, мөн тушаалын 2 дугаар хавсралтад химийн хортой бодисын ангилалыг тус тус оруулсан байдаг билээ. Энэ талаар 48 төрийн химийн бодисонд тусгай зөвшөөрөл авч ажиллав.

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
1	Химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны сургалт	Химийн бодистой ажилладаг ажилчид хор аюулын мэдлэгтэй болох	100%
2	Хүчил шүлтэнд тэсвэртэй тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангах	Тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг тогтсон стандартаар хангаж ажиллах	100%
3	Химийн хорт болон аюулгүй бодисын хог хаягдлыг устгах	Химийн хортой хог хаягдлыг бүртгэж, устгах акт хөтлөх	100%
4	Химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, болзошгүй аюулын үед аврах баг бэлтгэх	Химийн хорт бодистой агуулахын аюулгүй байдал хамгаалалтыг сайжруулах, гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах	100%
5	Химийн бодисын хэрэглэх тусгай зөвшөөрөл авах	Байгаль орчин аялал жуулчлалын яаманд шаардлагатай материалыг бүрдүүлж хэрэгжилтийг хангах	100%

#### 6.1 Химийн бодис хор аюулын тухай аюулгүй ажиллагааны сургалт

Эрх бүхий мэргэжлийн байгууллагаас химийн бодистой харьцаж ажилладаг лабораторын ажилчдад химийн бодисын хор хөнөөлийн талаар болон зохиох мэдлэгийг, сургалтын тэдгээрийн ажилтнуудын химийн бодисын талаархи хууль, эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтыг үйлдвэрийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж ажиллав.

Зураг 18. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдын сургалт.



### 6.2 Хүчил шүлтэнд тэсвэртэй тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангах

Химийн агуулахад орохдоо тусгай зориулалтын маск болон хүчил шүлтэнд тэсвэртэй бээлий хамгаалалтын хувцас өмсөж орох ёстой. Химийн бодис хаягдлыг хадгалахдаа химийн шинж чанарыг харгазан үзэх шаардлагатай. 2023 оны үйлдвэрлэлийн чанарын судалгааны лабораторид хэрэглэх ажлын хувцас болон хүчил шүлттэй орчинд хэрэглэх тусгай хамгаалалтын хувцасыг ажлын байруудад бүрэн хангаж ажиллах ажил үүргийг гүйцэтгүүлж байна.

### 6.3 Химийн хортой хог хаягдлыг бүртгэж, устгах акт хөтлөх

Монгол улсын хэмжээнд аюултай хог хаягдлыг устгах эрх бүхий мэргэжлийн байгууллага буюу “Элемент” ХХК-д

-Хүчлийн холимог хаягдал 44л

- Бодисын хоосон сав 14.3 кг            Нийт: 58.3 кг идэмхий хортой бодисыг устгуулав.

#### Устгасан аргачлал:

Идэмхий болон хортой хаягдлыг “Элемент ХХК -ийн аюултай хог хаягдал хүлээн авах устгах комисс хүлээн авч саармагжуулан зориулалтын шатаах зууханд  $1150^{\circ}\text{C}$  д бүрэн шатааж хаягдал үнсийг ландфиллдэж устгав.

/хавсралтанд албан ёсны хаягдлыг устгасан актыг хавсаргав. /



*Зураг 19. Химийн бодисын шингэн хаягдал мөн сав баглаа боодлыг ачиж буй байдал*

#### **6.4 Химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, болзошгүй аюулын үед аврах баг бэлтгэх**

